



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 08 өдөр

Дугаар 82

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Монгол Улсын Гавьяат барилгачин”- аар

1. Тогооч Тогтох - Ховд аймгийн Мөст сумын “Мотоблок” компанийн зөвлөх инженер

“Монгол Улсын Үйлчилгээний Гавьяат ажилтан”- аар

1. Доржготов Янжинсүрэн - Жаргалант сумын Жаргалан баг
“Заяа-Дэлгэрэх” ХХК захирал

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор

1. Дагдан Чойсүрэн - Цэцэг сумын Хажинга багийн иргэн

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор

1. Самдаг Дагва - Ховд аймгийн Үенч сумын өндөр настан

0000248

“Алтан гадас одон”-гоор

1. Пүрэвдорж Санжидмаа - Жаргалант сумын Магсаржав
багийн иргэн
2. Түдэв Догмидцэрэн - Жаргалант сумын Хайрхан
багийн иргэн
3. Сэрээтэр Шилэг - Булган сумын Далт багийн
өндөр настан
4. Мөнхөө Батбаяр - Жаргалант сумын Жаргалан
багийн иргэн
5. Лэгшид Баатаржав - Жаргалант сумын Наран багийн
иргэн
6. Магсар Цэрэндорж - Булган сумын Далт багийн Засаг
дарга
7. Сэсээр Уламбаяр - Цэцэг сумын Цэцэг нуур
багийн иргэн

“Хөдөлмөрийн хүндэт медаль”- аар

1. Лхасүрэн Дэмбэрэл - Жаргалант сумын Хайрхан багийн
өндөр настан
2. Янжин Пүрэвдорж - Жаргалант сумын Баатархайрхан
багийн иргэн
3. Дамиран Энхтуяа - Булган сумын нэгдсэн эмнэлгийн
сувилагч
4. Смайл Асалгүл - Булган сумын нэгдсэн эмнэлгийн
сэхээн амьдруулах,
мэдээгүйжүүлэгийн сувилагч
5. Бүргэд Алтантуяа - Булган сумын нэгдсэн эмнэлгийн эх
баригч бага эмч
6. Тарьваадай Баянбулаг - Булган сумын нэгдсэн эмнэлгийн
сувилагч
7. Даваа Оюунчимэг - Цэцэг сумын Цэцэг нуур багийн
өндөр настан

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 83

Ховд

Дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.2, 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалтуудыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагчаас өргөн мэдүүлсэн орон нутгийн 2020 оны төсвийн төсөл, 2021-2022 оны төсвийн төсөөллийн саналыг дэмжсүгэй.

2. Төсвийн төсөлд аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Тэргүүлэгчдээс гарсан саналыг тусган холбогдох яамдад өргөн мэдүүлж улсын нэгдсэн төсөвт тусгуулах арга хэмжээ авахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 08 сарын 02 өдөр

Дугаар 84

Ховд

Нээлттэй дуудлагын худалдаа
зарлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, 31.3, 77.2 дугаар зүйлийн 77.2, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2016 оны 128 дугаар тогтоолын 5.2, 2.3 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Ховд аймгийн Цагдаагийн газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй, цаашид ашиглах боломжгүй болсон 10914000 төгрөг /арван сая есөн зуун арван дөрвөн мянга/-ийн үнэ бүхий 4395916 /дөрвөн сая гурван зуун ерөн таван мянга есөн зуун арван зургаа/-ийн элэгдэлтэй, 6518084 төгрөг /зургаан сая таван зуун арван найман мянга наян дөрөв/-ийн үлдэх өртөгтэй үл хөдлөх хөрөнгийн худалдах доод үнийг хавсралтаар баталсугай.

2.Нээлттэй дуудлагын худалдааг аймгийн Нутгийн удирдлагын ордонд 2019 оны 09 дүгээр сарын 04-ний өдөр зохион байгуулсугай.

3.Хавсралтанд тусгагдсан хөрөнгө борлуулсан орлогын 80 хүртлэх хувийг аймгийн Цагдаагийн газарт хөрөнгө бүртгэхэд зарцуулахыг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагч /Б.Дүгэржав/-д зөвшөөрсүгэй.

4.Нийтийн дуудлагын худалдаагаар худалдах хөрөнгийн зарыг олон нийтэд ил тод мэдэээлж, холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулан борлуулсан орлогыг аймгийн өмчийн санд төвлөрүүлэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтөд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Ш.Нохойжав/-д үүрэг болгосугай.



ХУРЛЫН ДАРГА

Г.ПҮРЭВГАНДИ

0000252

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2019 оны
84 дүгээр тогтоолын хавсралт



ХОВД АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДУУДЛАГЫН
ХУДАЛДААГААР ХУДАЛДАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛ

/ Төгрөгөөр /

№	Эзэмшигч байгууллагын нэр	Ашиглалтанд орсон он	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг	Үнийн санал
1	Захын доод талын кабоны байр	2012	10914000	4,395,920.00	6,518,084.00	6,518,084.00

.....оо.....



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 85

Ховд

Дулааны нийлүүлэлтийн тооцоог
тоолуурт шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.Төсвийн үр ашгийг дээшлүүлж, төрийн үйлчилгээний байгууллагуудын иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор нэгдсэн халаалтын системд холбогдсон сумдын төсөвт байгууллагуудын дулаан нийлүүлэлтийн тооцооллыг тоолуурт шилжүүлэн тооцох ажлыг 2020 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн үе шаттайгаар хэрэгжүүлэхээр тогтоосугай.

2.Нэгдсэн халаалтад холбогдсон хөдөөгийн сумдын төсөвт байгууллагуудыг дулааны тоолуурт шилжүүлэх бэлтгэл ажлыг хангаж, шаардлагатай төсвийг шийдвэрлэн үе шаттайгаар шилжүүлэх ажлыг хэрэгжүүлж ажиллахыг аймгийн Засаг дарга, төсвийн ерөнхийлөн захирагч /Б.Дүгэржав/-д үүрэг болгосугай.

3.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ

0000256



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 86

Ховд

Уриалгыг дэмжих тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны 8 дугаар Хуралдааны “Аймгийн төсөв батлах тухай” 8/04 дүгээр тогтоолын 16 дахь заалт, Дэлхийн хөөмийн холбооны 2019 оны 8 дугаар сарын 14-ны өдрийн 139 дүгээр албан бичгээр ирүүлсэн уриалга, аймгийн Засаг даргын 2019 оны 1/2035 тоот бичгээр ирүүлсэн саналыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн ардын авьяастнууд, мэргэжлийн урлагийн байгууллагуудаас хөөмийн өв соёлыг тээгчийн хувьд дэлхийн дээд амжилтад бүртгүүлэх талаар гаргасан санал санаачилгыг дэмжиж, тус арга хэмжээг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийг сайн үйлсийн аян өрнүүлж бүрдүүлэх, хөөмийн урлагаар Гиннесийн амжилтын эзэд болж үндэсний бахархлыг бий болгох Дэлхийн хөөмийн холбооны уриалгыг дэмжсүгэй.

2. Аймгийн ардын авьяастнууд, мэргэжлийн урлагийн байгууллагуудын санаачилга, Дэлхийн хөөмийн холбооны уриалгыг дэмжиж, Хөөмийг дэлхийн Гиннесийн амжилтад бүртгүүлэн үндэсний бахархлыг төрүүлэх сайн үйлсийг дэмжин нэгдэж хамтран ажиллахыг сум, төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, аж ахуйн нэгж, төсөл хөтөлбөр, төрийн бус байгууллага, хамт олон, ажилтан албан хаагчид, нийт иргэдэд уриалсугай.

3. Ховд аймгийн олон үндэстэн ястны бахархал болсон хөөмийн өв соёлыг Гиннесийн амжилтад бүртгүүлэн үндэсний бахархлыг төрүүлэх сайн үйлсийн санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэх болон хэрэгжүүлэх үйл ажиллагаанд удирдлага, зохион байгуулалтын бүх талын дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д үүрэг болгосугай.


0000264

4. Гиннесийн рекордыг бүртгэх газраас сорилтод оролцох эрх авах зардал болох 82.1 сая төгрөг /наян хоёр сая нэг зуун мянга/-ийг орон нутгийн санхүүгийн боломжит эх үүсвэрээс урьдчилан олгож, 2019 оны 11 дүгээр сарын 01-ний дотор буцаан төвлөрүүлэхийг аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /Б.Сандагсүрэн/-д даалгасугай.

ХУРЛЫН ДАРГА  Т. ПҮРЭВГАНДИ





ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 87

Ховд

Г Улсын физикийн 33 дугаар олимпиадыг Г
зохион байгуулах ажлын хэсгийн
бүрэлдэхүүнийг батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.7 дахь заалт, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улсын физикийн 33 дугаар олимпиадыг Ховд аймагт 2020 оны 04 дүгээр сард зохион байгуулан явуулах Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд:

Ажлын хэсгийн

ахлагч:	Б.Дүгэржав	- Аймгийн Засаг дарга
Гишүүд:	Ч.Уранчимэг	- Аймгийн Засаг даргын нийгмийн бодлого хариуцсан орлогч
	Б.Даваадорж	- Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
	М.Ганбат	- Физикийн Улсын олимпиадын хорооны дарга
	Д.Нарандорж	- Аймгийн БСУГ-ын дэд дарга
	Ж.Батбаяр	- Аймгийн ЗДТГ-ын Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн
	С. Ариунжаргал	- Хөгжимт Драмын Театрын дарга
	Ц.Мягмарцоож	- Аймгийн Музейн захирал
	Б.Нямдорж	- Ховд Их сургуулийн захирал
	Ц.Цэрэнгомбо	- Ховд Их сургуулийн Байгаль шинжлэл технологийн сургуулийн захирал
	Л. Мөнхбат	- Ховд Их сургуулийн Физик, инженерчлэлийн Тэнхмийн эрхлэгч
	Т.Цэцэгбадам	- Алтай сумын ЕБС-ийн захирал
	Г.Цэцэгмаа	- Булган сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн захирал

0000258

Ц.Сонгууль	- Минжит Булган цогцолбор сургуулийн захирал
Б.Оюунчимэг	- Буянт сумын ЕБС-ийн захирал
Д.Түмэн-өлзий	- Дарви сумын ЕБС-ийн захирал
Ц.Мөнхбат	- Дөргөн сумын ЕБС-ийн захирал
Г.Энхбадам	- Дуут сумын ЕБС-ийн захирал
Н.Галаа	- Зэрэг сумын ЕБС-ийн захирал
Ч.Энхтөр	- Манхан сумын ЕБС-ийн захирал
Ж.Батсайхан	- Мянгад сумын ЕБС-ийн захирал
Л.Тогтохбаяр	- Мөст сумын ЕБС-ийн захирал
Б.Батзаяа	- Мөнххайрхан сумын ЕБС-ийн захирал
Ш.Пүрэвдамба	- Чандмань сумын ЕБС-ийн захирал
Д.Манат	- Ховд сумын ЕБС-ийн захирал
Л.Нямжаргал	- Үенч сумын ЕБС-ийн захирал
Д.Мөнхтөр	- Цэцэг сумын ЕБС-ийн захирал
С.Отгончимэг	- Эрдэнэбүрэн сумын ЕБС-ийн захирал
У.Саруулзаяа	- Жаргалант сумын 1 дүгээр сургуулийн захирал
Ц.Цэрэнлхам	- Жаргалант сумын 2 дугаар сургуулийн захирал
Д.Гантогоо	- Жаргалант сумын 3 дугаар сургуулийн захирал
П.Алтанлхагва	- Цаст - Алтай цогцолбор сургуулийн захирал
З.Энхбаяр	- Прогресс сургуулийн захирал
Б.Барсболд	- Жаргалант сумын 6 дугаар сургуулийн захирал
Ц.Алтантунгалаг	- Жаргалант сумын 7 дугаар сургуулийн захирал

Нарийн бичгийн
дарга:

М.Пүрэвхүү - Аймгийн Боловсрол соёл урлагийн газрын дарга

2.Улсын олимпиадыг зохион явуулах бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргаж, удирдлагаар хангаж, хэрэгжилт дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, аймгийн Засаг дарга /Б.Дүгэржав/-д үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 88

Ховд

Мянган Угалзат” ОНӨААТҮГ-ын
төлөвлөгөө батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол улсын хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3-ийн “к”, 20 дугаар зүйлийн 20.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.2 дахь заалтууд, аймгийн Засаг даргын саналыг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1.“Мянган Угалзат” ОНӨААТҮГ-ын 2019 оны үйл ажиллагааны орлогын доод хязгаарыг 264752000 төгрөг /хоёр зуун жаран дөрвөн сая долоон зуун тавин хоёр мянга/, зарлагын дээд хязгаарыг 260 958 100 төгрөг /хоёр зуун жаран сая есөн зуун тавин найман мянга нэг зуу/, цалингийн санг 110869700 төгрөг /нэг зуун арван сая найман зуун жаран есөн мянга долоон зуу/, ашиг /алдагдал/-ийг 3793600 төгрөг /гурван сая долоон зуун ерэн гурван мянга зургаан зуу/ байхаар тус тус баталсугай.

2.“Мянган Угалзат” ОНӨААТҮГ - ын 2019 оны үйл ажиллагааны санхүүгийн төлөвлөгөөг зохих журмын дагуу салбар нэгж, зардлын ангилал бүрээр хуваарилан баталж мөрдүүлэн, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Ц.Бат-Эрдэнэ/-д, байгууллагын орлогыг нэмэгдүүлэн хөрөнгө, санхүүгийн үр ашгийг дээшлүүлж ажиллахыг гүйцэтгэх захирал /Н.Ганбат/-д тус тус үүрэг болгосугай.

ХУРЛЫН ДАРГА  Г.ПҮРЭВГАНДИ



0000266



ХОВД АЙМАГ
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ТОГТООЛ

2019 оны 08 сарын 27 өдөр

Дугаар 89

Ховд

Төрийн дээд шагналаар шагнуулахаар
өргөн мэдүүлэх тухай

Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлиг, аймгийн Засаг даргын санал, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоол, тэмдэглэлийг үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Улс нийгэмдээ олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж байгаа дараах хүмүүсийг төрийн дээд шагналаар шагнуулахаар Монгол Улсын Ерөнхийлөгчид өргөн мэдүүлсүгэй. Үүнд:

“Соёлын гавьяат зүтгэлтэн”-ээр

1. Рэнцэн Даваажав - Ховд аймгийн Чандмань сум, Урд гол багийн өндөр настан, Хөөмийч

“Гавьяат механикжуулагч”-аар

1. Иса Акий - Ховд аймгийн Буянт сум, Норжинхайрхан багийн өндөр настан

“Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-гоор

1. Мэндбуян Отгонханд - Жаргалант сум, Магсаржав багийн иргэн
2. Дашванд Баатар - Жаргалант сум, Тахилт багийн иргэн
3. Барат Мутан - Ховд сум, Улаанбураа багийн иргэн
4. Наваан Энхтуяа - Мянгад сумын ЗДТГ-ын ХАА-н тасгийн дарга
5. Чогсом Санжжав - Жаргалант сум, Хайрхан багийн өндөр настан

0000260

“Алтан гадас одон”-гоор

1. Содномдовжид Чанцал -Мэргэжлийн хяналтын газрын барилгын
техникийн хяналтын улсын байцаагч
2. Шагдармаа Оюунжаргал - Жаргалант сум, Хайрхан багийн иргэн

“Хөдөлмөрийн хүндэт медаль” - аар

1. Пүрэвжав Аззаяа -НААҮ-ний “Шим-Ус” ОНӨААТҮГазрын орон
сууцны засвар үйлчилгээний техникч
2. Хүрлээ Гантөмөр -НААҮ-ний “Шим-Ус” ОНӨААТҮГазрын
цэвэр усны шугамын слесарь
3. Янжин Пүрэвжав -НААҮ-ний “Шим-Ус” ОНӨААТҮГазрын
цэвэр усны өргөлтийн станцын операторчин
4. Намсрай Энхбаяр -НААҮ-ний “Шим-Ус” ОНӨААТҮГазрын
цэвэр усны шугамын слесарь
5. Азыхан Авдол -Мянгад сум, Баянхошуу багийн өндөр
настан
6. Готов Баасансүрэн -Мянгад см, Баянхошуу багийн өндөр настан
7. Зэвэг Даваадорж -Мянгад сум, Баян хошуу баг, Гагнуурчин
8. Дугар Насанбат -Мянгад сум, Баянхошуу багийн өндөр
настан
9. Гонгор Эрдэнэбаатар -Мянгад сум, Баянхошуу багийн малчин
10. Балдорж Баатарсүрэн -Мянгад сум, Баянхошуу багийн малчин
11. Шумаахүү Батжаргал -Булган сум, Далт багийн малчин
12. Очирбат Сүх-Очир -Жаргалант сум, Хайрхан багийн иргэн
13. Чоймоо Дүгэрсүрэн -Жаргалант сум, Хайрхан багийн өндөр
настан
14. Орших Даваахүү -Жаргалант сум, Цамбагарав багийн өндөр
настан
15. Пинээ Хоролсүрэн -Жаргалант сум, Бичигт багийн өндөр настан

ХУРЛЫН ДАРГА



Г.ПҮРЭВГАНДИ